БАТЛАВ.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОТГОНБАЯР

2016 оны 02 сарын 15 өдөр

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2016.02.05 Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаа | Хэрэг-жүүлэх хугацаа, хуваарь | Хариуцах нэгж, албан тушаалтан | Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:** | | | | | |
| 1 | Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавхийг сайжруулах хөтөлбөрт тусгах саналыг холбогдох албан хаагчдаас авах боломжийг бүрдүүлэх | II-IY улиралд | ТСХ | Орон нутгийн худалдан авах ажиллагааны албад | - Төслийг цахим хуудсанд байршуулж, санал өгөх нээлттэй боломжоор хангах,<br>- Бодлого, төлөвлөлтөд саналыг тусгах арга хэмжээ авах. |
| 2 | Боловсруулагдаж байгаа аливаа журам, дүрмийн төсөлд албан хаагчдын болон сонирхогч бүлгийн саналыг тусгах арга хэмжээ авах | Тухай бүрд | Бүх хэлтэс | Бүх хэлтэс | - Төслийг албан хаагчид болон сонирхогч бүлгэд хүргүүлэх, ил тод байршуулах,<br>- Төсөлд тусгах санал авч, нэгтгэн боловсруулалт хийх,<br>- Холбогдох этгээдээр батлуулан мөрдүүлэх арга хэмжээ авах. |
| 3 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх | жилдээ | ЗУХ | ХХХэлтэс | - Хуулийн холбогдох заалтыг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн байх,<br>- Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | авах ажиллагааны явцын талаарх мэдээлэл ил тод болсон байх.<br>- Шилэн дансны мэдээллийн ил тод байдалд хяналт тавьж ажилласан байх. |
| 4 | Санхүүгийн 2015 оны тайлан, аудитын дүгнэлт гаргуулж, цахим хуудсанд байршуулан мэдээлэх | Хуульд заасан хуга-цаанд | ЗУХ | Ахлах нягтлан бодогч | - Санхүүгийн тайланд аудит хийлгэсэн байх.<br>- Дүгнэлтийг ил тод мэдээлэх.<br>- Холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлсэн байх. |
| 5 | Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах | I сар | ХХХэлтэс | - | - Төлөвлөгөө боловсруулж батлуулсан байх,<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байх,<br>- Хяналт, шалгалтын дүнг газрын нийт албан хаагчид, олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Цахим хуудсанд төлөвлөгөө, хэрэгжилтийн талаарх мэдээллийг байрлуулсан байх. |
| 6 | Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, худалдан авах ажиллагааны явцад хийсэн аудитын тайлан, дүгнэлт, бусад, хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах | Жилдээ, тухай бүр | ХХХэлтэс | ЗУХ | - Цахим хуудсанд хуульд заасан хугацаанд байршуулан мэдээлсэн байх. |
| 7 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангах | Жилд | ЗУХ | Бүх хэлтэс | - Мэдээлэл нээлттэй, үр ашигтай, хүртээмжтэй байх,<br>- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны явцыг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшсэн байх,<br>- Байгууллагын цахим хуудас болон холбогдох бусад вэб хуудсанд мэдээллийг ил тод байршуулсан байх,<br>- Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх. |
| 8 | Авлигын эсрэг үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах | жилдээ | ЭБАТ | ЗУХ | - Шалгуур үзүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад хүргэж, танилцуулсан байх,<br>- Хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байх,<br>- Шалгуур үзүүлэлтийг хангаж, жилийн үнэлгээнд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдах.<br>- Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, 11 сарын 15-ны дотор нотлох баримтын хамтаар АТГ-т хүргүүлсэн байх. |
| 9 | Мэдүүлэг гаргагч албан хаагчдаас 2015 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах ажлыг зохион байгуулах, 2015 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан, ЭБАТ-ын ажлын тайланг гаргаж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх | I-II сард | ЭБАТ | Бүх хэлтэс | - ХАСХОМ-ыг хугацаанд нь гаргаж мэдүүлсэн байх,<br>- 2015 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн тайлан зөрчилгүй гарсан байх, тайланг АТГ-т хүргүүлсэн байх,<br>- 2015 оны ЭБАТ-ын ажлын тайланг гаргаж, АТГ-т 03 сарын 01-ний дотор хүргүүлсэн байх. |
| 10 | Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг холбогдох албан хаагчдаас гаргуулан авч, бүртгэх | Жилд | ЭБАТ | Байгуулагдсан үнэлгээний хороод, Ажлын хэсгүүд, шалгалтын комисс | - Мэдэгдлийг тухай бүр гаргуулан авах,<br>- Мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд мэдэгдлийн мэдээллийг бүртгэн оруулсан байх,<br>- Мэдээллийн санг үүсгэн хяналт тавьж ажиллах. |
| 11 | Мэдүүлэг бүрдүүлэлтийн программ дахь "ЭБАТ" цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөн мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч, албан хаагчдад холбогдох зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх | жилдээ | ЭБАТ | - | - Хуульд заасан хугацаанд бүртгэл, бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байх,<br>- Заавар, зөвлөмжийг холбогдох албан хаагч бүрт хүргэж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. |
| 12 | Байгууллагын үйл ажиллагаа, тендер шалгаруулалтын ил тод байдал, төрийн үйлчилгээний талаар иргэд, ААН, байгууллагаас сэтгэл ханамжийн судалгаа авч, цаашид авах арга хэмжээг тодорхойлох | III, IX сард | ТСХ | ХХХэлтэс | - Санал асуулгын хуудас боловсруулан бэлтгэх,<br>- Судалгааг 200-аас доошгүй иргэд, ААН, байгууллагаас авч, дүн шинжилгээ хийх,<br>- Дүнг олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх. |
| 13 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэл хөтлөн хэрэгжилтийг хангах зохион | жилдээ | ЗУХ, ХХХэлтэс | АТГ | - Бүртгэлээр хяналт тавих,<br>- Удирдлагуудад танилцуулан хэрэгжилтийг хангах,<br>- Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцон холбогдох байгууллага, удирдлага, олон нийтэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байгуулалтын арга хэмжээ авах | | | | танилцуулах. |
| 14 | Худалдан авах ажиллагаанд техник технологийн дэвшлийг ашиглан олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллах | жилдээ | МТИХ | ХААЗБХ, ХХХэлтэс | - Гар утасны аппликэйшнийг ашиглалтад оруулсан байх,<br>- Иргэдийн гар утсанд худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл очдог болсон байх,<br>- Иргэдийн санал, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэн хариу өгсөн байх. |
| 15 | Тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэлийг худалдан авах ажиллагааны цахим систем, байгууллагын цахим хуудсанд тодорхой байршуулах | жилдээ | ХААЗБХ | МТИХ, ХХХэлтэс | - Цахим хуудсанд тендерийн үр дүнг мэдээлэхдээ ХХХэлтсээр урьдчилан хянуулж, олон нийтэд мэдээлэх,<br>- Цахим хуудаснаас мэдээллийг тодорхой авах боломжтой байх. |
| 16 | ХААГ-ын зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ТББ-ын төлөөллийг оролцуулж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх | жилдээ | ХХХэлтэс | ХААЗБХ | - Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах урилгыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ төслийг цахим хуудсанд байршуулах,<br>- Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалт тусгах,<br>- Хамтран ажиллах гэрээ байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулах,<br>- Мэдээллийн бааз үүсгэсэн байх. |
| 17 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг санамсаргүй сонголтын аргаар сонгон томилох | Тухай бүр | МТИХ, ХХХэлтэс | ТСХ | - Санамсаргүй сонголтоор сонголт хийх программ хангамжийг тестэлж бэлтгэсэн байх,<br>- Үнэлгээний хорооны гишүүдийн мэдээллийн баазыг бүрдүүлсэн байх,<br>- Мэдээллийн баазаас цахим программын тусламжтайгаар үнэлгээний хорооны гишүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон байх. |
| 18 | Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлалыг олон нийтэд мэдээлж, хамтран ажиллах | II сард | ЗУХ, ХААЗБХ | Ажлын хэсэг | - Хамтран ажиллах сонин сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулан ажиллуулах,<br>- Сонгон шалгаруулалт зарлах, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | өдөр тутмын 3 хүртэлх сонинг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | | | | - Шалгарсан сонингуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах,<br>- Авилага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах талара тодорхой заалтыг гэрээнд тусгасан байх,<br>- Шалгарсан сонинд зар, мэдээлэл нийтлэгдэж тогтмолжсон байх. |
| 19 | Тендерийн баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авах | жилдээ | ЗУХ, XXXэлтэс | Бүх хэлтэс | - CD хадгалах тоног, төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэсэн байх,<br>- Тендер баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах, лацдаж бүртгэлжүүлэх,<br>- Цахим архив үүсгэсэн байх. |
| 20 | Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших | Улирал бүр | ЗУХ | - | - Улирлын мэдээ гаргаж, шийдвэрлэлтийн байдлыг улирлаар мэдээлсэн байх,<br>- Цахим хуудсанд байршуулан мэдээлэх. |
| 21 | Давхар ажил эрхлэлтийн байдлыг судлан дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах | X сард | ЗУХ | - | - Хуулийн холбогдох заалтыг албан хаагчдад таниулан сануулах,<br>- Судалгааг бичгээр авах.<br>- Дүгнэлт хийж, удирдлагад танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авах. |
| 22 | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтэд дүгнэлт хийх | Y, XI сард | Ёс зүйн хороо | XXXэлтэс | - Ёс дүрмийн заалт бүрийг сурталчлан таниулах,<br>- Холбогдох бусад дүрэм, журамтай уялдуулан сурталчлах,<br>- Хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт хийх,<br>- Нийт албан хаагчдад танилцуулах. |
| 23 | Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах | Тухай бүр | ЗУХ | Бүх хэлтэс | - ТББ-ын үйл ажиллагааг дэмжих. |
| | **Хоёр. Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:** | | | | |
| 24 | Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хууль тогтоомжийг | III сард | ЗУХ | АТГ, Сангийн яам | - Сангийн яамнаас боловсруулсан сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах талаар тодорхой заалт оруулж батлах асуудлыг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | таниулах талаар тусгах арга хэмжээг авах | | | | шийдвэрлүүлэх. |
| 25 | Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчдад зориулсан зорилтот сургалт зохион байгуулах | IY, IX сард | ЗУХ | АТГ | - Зорилтот сургалтын хөтөлбөр боловсруулах,<br>- АТГ-тай хамтран сургалт зохион байгуулах. |
| 26 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар Үнэлгээний хороонд ажиллах ТББ-ын төлөөллүүдэд семинар өгөх | III сард | ЗУХ, ХХХэлтэс | ХААЗБХ | - Семинарын хөтөлбөр боловсруулж батлуулах,<br>- Нэгдсэн семинар зохион байгуулах,<br>- АТГ-аас дэмжлэг авах. |
| 27 | Нийт албан хаагчдын авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | III, X сард | ЗУХ | АТГ | - Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтох,<br>- Сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан байх. |
| 28 | Хууль тогтоомжийн мэдлэг сорих, танин мэдэхүйн агуулгатай тэмцээн, уралдаан зохион байгуулах | YI сард | ЗУХ, ХХХэлтэс | Бүх хэлтэс, АТГ | - Удирдамж боловсруулж, хэлтсүүдэд хүргэх,<br>- Төсөв, шийдвэрийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх,<br>- Арга хэмжээний хөтөлбөртэй байх,<br>- Тэмцээн – уралдааныг зохион байгуулах. |
| 29 | Удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэх арга хэмжээ зохион байгуулах | IY сард | ЗУХ | Бүх хэлтэс, АТГ | - Арга хэмжээг тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан байх,<br>- Хэлтсийн дарга нар хамрагдсан байх. |
| 30 | Нээлттэй өдөрлөг зохион байгуулж, ХААГ-ын 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, явц, үр дүнг олон нийтэд ил тод сурталчлан таниулах | II, IX сард | ЗУХ, МТИХ | Бусад бүх хэлтэс оролцох | - Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах,<br>- Цахим худалдан авах ажиллагааны сурталчилгаа хийх,<br>- Сургалт сурталчилгааны материал бэлтгэсэн байх. |
| 31 | Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, | жилдээ | ЗУХ | АТГ | - Зөвлөгөө, дэмжлэгээр хангаж, чиглэл, зөвлөмж өгч ажиллах,<br>- Семинар өгөх,<br>- Зөрчил, доголдол бүртгэгдээгүй, бүртгэгдсэн бол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллах талаар АТГ-тай хамтран ажиллах | | | | шийдвэрлэх арга хэмжээг цаг тухайд авсан байх. |
| 32 | Шударга ёс, ёс зүйн асуудлаар хамт олны дунд ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэх | Y сард | ЗУХ | Ёс зүйн хороо | - Ярилцлагын агуулгыг тодорхойлж, голлох асуултуудыг урьдчилан боловсруулах,<br>- Бэлтгэсэн агуулга, асуултыг тойрон хэлэлцүүлэг өрнүүлэх. |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ЖАРГАЛАН

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН, ЭБАТ Х.ЭНХЧИМЭГ